



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Удирдамж, хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 19, 21, 23, 26 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/456, 2021 оны А/276 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон он дамжин хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажилд стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулж мөрдүүлэх, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, дээрх арга хэмжээнд оролцох албан хаагчдын хуваарийг хоёрдугаар хавсралтаар, барилга байгууламжийн их засвар, шинэчлэлт, тохижилт, шугам сүлжээний ажлын зөвлөмжийн хуудсыг гуравдугаар хавсралтаар, хяналт тавьж ажиллахад ашиглагдах илтгэх хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу хөрөнгө оруулалтын ажилд стандарт, нормыг мөрдүүлэх талаар албан хаагчдад зөвлөгөө мэдээлэл өгч, удирдлага, арга зүйгээр хангаж, хэрэгжүүлсэн ажлын тайланг газрын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтэс (О.Оджаргал)-т даалгасугай.

ДАРГА



С.ТОМОРДУЛАМ

1150500152

Газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/34 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



**ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖИЖ БУЙ ТОХИЖИЛТ,
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД СТАНДАРТ, НОРМ, ДҮРМИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХАД ХЯНАЛТ ТАВЬЖ, ЗӨВЛӨН ТУСЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ**

2022 оны 06 дугаар сарын 23

Улаанбаатар хот

НЭГ. Зорилго: Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2022 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудад стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах, газар дээр нь хянаж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулан ажиллах

ХОЁР. Хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 31

ГУРАВ. Хамрах хүрээ: Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй тохижилт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ

ДӨРӨВ. Харилцах байгууллага

- Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба
- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
- Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар
- Тухайн төслүүдийн захиалагчийн хяналт гүйцэтгэгч байгууллагууд
- Гүйцэтгэгч байгууллагууд

ТАВ. Ажлын чиглэл: Тохижилт бүтээн байгуулалтын ажлын байршил дээр зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулах албан хаагчид өөрийн хуваарилагдсан дүүрэгт дараах ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Шаардлагатай мэдээллийг цуглуулж бэлтгэл ажлыг хангах
- Холбогдох албан хаагчид, ажил гүйцэтгэгчидтэй холбогдож хуваарь гаргах
- Тохижилт бүтээн байгуулалтын ажлын байршлуудад ажиллаж, зөвлөн туслах, аргагүйгээр хангах /зөвлөмжийн хуудас/
- Стандартын шаардлага хангаж байгаа эсэх мэдээллийг программ ашиглан бүртгэл хийх
- Өгөгдсөн загварын дагуу илтгэх хуудас бичиж, зөвлөмжийн хуудасны хамт тайланг нэгтгэх албан хаагчид өгөх

ЗУРГАА. Төхижилт бүтээн байгуулалтын ажлын төрөл, мөрдүүлэх баримт бичгүүд

Д/Д	Ажлын төрөл	Мөрдүүлэн ажиллах удирдамж, арга зүйн баримт бичгийн нэр
1	Хүүхдийн тоглоомын талбай	<ul style="list-style-type: none"> • “UCS1405B:2022 Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага” баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах
2	Сургууль, цэцэрлэгийн барилга, гадна орчны тохижилт	<ul style="list-style-type: none"> • UCS1101B:2022 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага • UCS1102B:2022 Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага • UCS1410B:2022 Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ зэрэг холбогдох стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах талаар хяналт тавьж ажиллах
3	Явган хүний зам	<ul style="list-style-type: none"> • UCS0901B:2022 Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага • UCS0903B:2022 Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах шаардлага баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
4	Гэрэлтүүлэг	<ul style="list-style-type: none"> • UCS 1901B:2022 Гэрэлтүүлэгт тавигдах шаардлага • UCS1902A:2022 Гэрэлтүүлэх төхөөрөмжийг байрлуулах, суурилуулах технологийн удирдамж баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
5	Биеийн тамир чийрэгжүүлэлтийн талбай	<ul style="list-style-type: none"> • UCS 1409B:2022 Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлага баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
6	Авто зогсоолын талбайн тохижилт	<ul style="list-style-type: none"> • USC 0902B:2020 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, удирдамж арга зүйн зөвлөмж өгөх
7	Гадна талбайн тохижилт	<ul style="list-style-type: none"> • UCS0901B:2022 Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага • UCS 1901B:2022 Гэрэлтүүлэгт тавигдах шаардлага • UCS1406B:2022 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах хогийн саванд тавигдах шаардлага • UCS1407B:2022 Нийтийн эзэмшлийн талбайн сандалд тавигдах ерөнхий шаардлага • UCS1404B:2022 Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага • UCS 1402B:2022 Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт тавигдах ерөнхий шаардлага баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, удирдамж арга зүйн зөвлөмж өгөх
8	Ногоон байгууламж	<ul style="list-style-type: none"> • UCS 0801A:2022 Хот суурин газрын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөлтийн удирдамж

		<ul style="list-style-type: none">• UCS 0803A:2022 Мод таримал ургамлын төрөл зүйлийн лавлах баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, удирдамж арга зүйн зөвлөмж өгөх• UCS 0803B:2022 Ногоон байгууламжийн арчилгаанд тавигдах шаардлага
--	--	--

ДОЛОО. Тайлагнах:

- Хуваарьт өдөр ажилласан ажлын явц, үр дүнг илтгэх хуудас бичиж, нэгтгэн Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн даргад танилцуулах, үүрэг чиглэл авч ажиллах
- Бусад хэлтэс, албан хаагчдад мэдээлэл өгөх, шаардлагатай стандарт, норм, дүрмийг судлах
- Ажлын явцад авсан фото зураг, тайланг байгууллагын дотоод сүлжээнд хадгалах

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

-----oO-----

Газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 1/34 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



ДҮҮРГҮҮДИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХИЙГДЭЖ БУЙ ТОХИЖИЛТ,
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ХЯНАЛТ ТАВИХ АЛБАН
ХААГЧДЫН ХУВААРЬ

Д/д	Хариуцах дүүрэг	Хариуцах албан хаагч нар
1	Баянзүрх	Л.Хүрэлтушаа /СХХХ-ийн мэргэжилтэн/ Ц.Номин /ХНААСХ-ийн мэргэжилтэн/ Зөвшилцсөнөөр: О.Түвшинтөгс /БЗД-ийн ЗДТГ-ын ТНААХ-ийн Мэргэжилтэн 85510067/
2	Чингэлтэй	М.Чингүн /СХХХ-ийн мэргэжилтэн/ Б.Ундармаа /ХНААСХ-ийн мэргэжилтэн/ Х.Энхбат /ЧД-ийн ЗДТГ-ын ТНААХ-ийн Ахлах мэргэжилтэн 99171883/
3	Сүхбаатар	Б.Батчимэг /СХХ-ийн Ахлах мэргэжилтэн/ Зөвшилцсөнөөр: Ц.Бэлгүдэй /СБД-ийн ЗДТГ-ын ТНААХ-ийн Тохижилт, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн 89112279/
4	Баянгол	Ц.Тогтохбуян /СХХ-ийн Ахлах мэргэжилтэн/ Зөвшилцсөнөөр: Г.Нямсүрэн /БГД-ийн ЗДТГ-ын Тохижилт, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн 88457665/
5	Хан-Уул	Т.Цолмонтуяа /СХХХ-ийн мэргэжилтэн/ Э.Гэрэлт-Од /ХНААСХ-ийн мэргэжилтэн/ Зөвшилцсөнөөр: Б.Нарандулам /ХУД-ийн ЗДТГ-ын ТНБГХХ-ийн Авто зам, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн 80030038/
6	Сонгинохайрхан	Б.Чимэдцэеэ /СХХХ-ийн мэргэжилтэн/ С.Гүлдана /ХНААСХ-ийн мэргэжилтэн/ Зөвшилцсөнөөр: М.Энхманлай /СХД-ийн ЗДТГ-ын ТНААХ-ийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга 88070297/
7	Багахангай	А.Энхзаяа /СХХХ-ийн мэргэжилтэн/
8	Багануур	Г.Бүтэнбаяр /ХНААСХ-ийн мэргэжилтэн/ Зөвшилцсөнөөр:
9	Налайх	Ё.Гэрэлцэцэг /БХД-ийн ЗДТГ-ын ТХҮҮХ-ийн Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн, 95022274/ Д.Дэмчигжав /БНД-ийн ЗДТГ-ын ТНААХ-ийн дарга 99027105 / Т.Зулзаяа /НД-ийн ЗДТГ-ын Архитектур, тохижилт, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн/
10		Ц.Номин /ХНААСХ-ийн мэргэжилтэн/

	9 дүүрэгт хэрэгжих шугам сүлжээний ажил	Л.Хүрэлтушаа /СХХХ-ийн мэргэжилтэн/
11	Тайлан нэгтгэх	Б.Чимэдцэеэ /СХХХ-ийн мэргэжилтэн/



Газрын даргын 2022 оныг 06 дугаар сарын 23-ны өдрийн 4/34 дүгээр тушаалын гуравдугаар хэвсрэлт



ЗАГВАР 1

ЗӨВЛӨМЖИЙН ХУУДАС

2022 оны-р сарын

№.....

Улаанбаатар хот

1. Хотын стандарт, хяналтын газарт үлдэх хэсэг

1. Ерөнхий мэдээлэл	
Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал:	Байршил: Дүүрэг..... Хороо:..... Гудамж, байршлын нэр.....
Захиалагч байгууллага. Захиалагчийн хяналтын инженерийн овог, нэр	Ажлын төрөл /аль тохирохыг сонгох/ <input type="checkbox"/> Сургууль цэцэрлэгийн гадна тохижилт <input type="checkbox"/> Бичил цэцэрлэг, ногоон байгууламж <input type="checkbox"/> Явган хүний зам, талбай <input type="checkbox"/> Усан оргилуур, хөшөө дурсгал <input type="checkbox"/> Гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл <input type="checkbox"/> Авто зогсоол <input type="checkbox"/> Хүүхдийн тоглоомын талбай <input type="checkbox"/>
Ерөнхий гүйцэтгэгч:	Ажлын гүйцэтгэл /хувиар/:
Төсвийн ангилал:	Төсөвт өртөг:
(Улс, нийслэл, ОНХС, бусад)	
Илэрсэн зөрчил дутагдал:	Зөвлөмж хүлээн авсан: Захиалагч байгууллагыг төлөөлж Албан тушаал Нэр.....

2. Тохижилт, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэгчид үлдэх хэсэг

2. Зөрчил дутагдал	
Илэрсэн зөрчил, дутагдал:	
3. Баталгаажилт	
Зөвлөмж бичсэн: ХСХГ-ыг төлөөлж Албан тушаал Нэр..... Гарын үсэг _____ Утасны дугаар.....	Зөвлөмж хүлээн авсан: Захиалагч байгууллагыг төлөөлж Албан тушаал Нэр..... Гарын үсэг _____ Утасны дугаар

Газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 1/34 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт



ЗАГВАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2022 оны ... дугаар сарын ...

Улаанбаатар хот

..... дүүргийн тохижилт бүтээн байгуулалтын ажлуудад хяналт тавьж ажилласан тухай

НЭГ. ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Жишээ: Хотын стандарт, хяналтын газрын мэргэжилтэн А.Энхзаяа Багахангай, Налайх, Багануур дүүрэгт хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил - 5, сагсан бөмбөгийн талбайн тохижилтын ажил - 3, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт бүтээн байгуулалтын ажил - 1, дугуйн замын ажил - 1, сагсан бөмбөгийн талбайн тохижилтын ажил - 1 тус тус хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч ажиллав/

ХОЁР. ЗУРАГ

Д/д	Зураг	Тайлбар
1	<div style="border: 1px solid black; width: 100px; height: 100px; display: flex; align-items: center; justify-content: center;">Зураг оруулах</div> <p>Зургийн нэр /байршил/</p>	Стандарт шаардлага хангасан, хангаагүй тухай зургийн тайлбар
2
3		

ИЛТГЭХ ХУУДАСТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА:

С.ТӨМӨРДУЛАМ

ХЯНАСАН:

СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА:

О.ОДЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Б.ЧИМЭДЦЭЭ